

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1.	Албан шаардлага өгөгдсөн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1.	Авлагын талаар .....	11
3.2.	Барьцаа дансны талаар .....	11
3.3.	Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалтын талаар.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	20

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## 1 Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/236  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үндэсний хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig\_Kheregi\Yawsan\_Bichig\2019\0224SAG24.Docx


070528

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2 Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний хөгжлийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 11-нээс 2019 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Үндэсний хөгжлийн газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 01/88 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Үндэсний хөгжлийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Үндэсний хөгжлийн газар нь “Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д нийцсэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, хөрөнгө оруулалтын болон концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг судалгааны үндэстэйгээр боловсруулж, хэрэгжүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, салбарын хөгжлийн бодлогыг хүн амын нутагшилт, суурьшил, бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан хүн амын ажиллаж, амьдрах эдийн засгийн таатай орчныг бий болгох явдал мөн” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үндэсний хөгжлийн газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Улсын хөгжлийн цогц бодлого, үндэсний хэмжээний урт, дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийг боловсруулах,
2. Бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг боловсруулж, батлуулах,
3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах,
4. Гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжын биелэлтийг хангах, хяналт тавих,
5. Гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэн ажиллажээ.

Үндэсний хөгжлийн газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Үндэсний хөгжлийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Концессын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Үндэсний хөгжлийн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Үндэсний хөгжлийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Үндэсний хөгжлийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Үндэсний хөгжлийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж,

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *нийт зардлын 2* хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож, нийт зардлын 2 хувь буюу 28,087.9 мянган төгрөгөөр материаллаг түвшинг тогтоосныг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудлыг аудитын явцад залруулсан болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	26,842.8	
2	Албан шаардлага өгсөн	3	29,891.5	
	Дүн	6	56,734.3	

### 2.8.1. Албан шаардлага өгөгдсөн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хадатын хүрээ ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдөр ҮХГ/079 дугаартай "Байгууллагын чиг үүргийн шинжилгээ, давхардал хийдлийг арилгах судалгааны ажлыг гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулж 9,300.0 мянган төгрөгийн төлбөртэй гүйцэтгүүлсэн,

- Жи Эс Эй Эс ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр ҮХГ/080 дугаартай "Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төслүүдийн бүртгэл хөтлөх, тэдгээрийн явц болон хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж ажлын үр дүнг харгалзахгүйгээр 8,963.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,

- Тайлант онд гадаад албан томилолтоор ажиллахдаа бизнес ангиллын нислэгээр зорчиж илүү төлсөн 6,544.5 мянга, томилолтын хугацааг хэтрүүлэн ажилласан хугацаанд тооцож олгосон 5,083.5 мянга, нийт 11,628.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, мөн Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 5-д "... төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага өгөх.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагаас худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлж буй "Судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээний ажил"-ын үр дүнг тооцох асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Үндэсний хөгжлийн газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 30 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 80,715,952.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 80,621,626.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын гүйцэтгэлээр 94,326.2 мянган төгрөг буюу 0.1 хувьтай хэмнэгдсэн байгаа нь Концессын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад 4 төслийг хэрэгжүүлээгүй, хуулийн дагуу чөлөөтэй байгаа албан хаагчдын оронд шинээр ажилтан авч ажиллуулаагүй, төсөл сонгон шалгаруулалтын үр дүнд төслийн төсөвт өртөг буурсан зэргээс шалтгаалжээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төслийн 181,783.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан ба оны эцэст зарцуулагдаагүй 20,419.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Үндэсний хөгжлийн газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

## **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### **3 Менежментийн захидал**

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үндэсний хөгжлийн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих 3 асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

### **3.1. Авлагын талаар**

“Удам соел” ХХК-тай 2018.12.26-ны өдөр байгуулсан "Судалгаа, шинжилгээний ажлын болон үйл ажиллагааны тайлангийн эмхэтгэл хэвлүүлэх" ажлын гэрээнд гүйцэтгэх хугацаа заагаагүй, мөн төлбөрийг 100 хувь буюу 9,405.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн, алданги тооцоогүй, ажил гүйцэтгэж дуусаагүй тул авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

### **3.2. Барьцаа дансны талаар**

Барьцааны дансанд 2017 оны концессын эргэн төлөлтийн үлдэгдэл 4,786.274.3 мянган төгрөгийг байршуулсан ба хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Зөвлөмж: Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх.

### **3.3. Бараа үйлчилгээний бусад зардлын зарцуулалтын талаар**

Бараа үйлчилгээний бусад зардлаас олгосон үйлчилгээний төлбөрөөс дарс, пивоны үнэ 264.4 мянган төгрөг, гадаад арга хэмжээний хүлээн авалтын зардалд 17,173.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан, мөн дотоод томилолтын зардлаас зочны зардалд 10,875.4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,756,933,767.82</b>	<b>23,414,249,683.07</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,757,198,636.00	23,329,342,997.56
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	688,600.00
31110	Төгрөг	00.00	688,600.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,757,198,636.00	23,328,654,397.56
3121	Төгрөг	11,757,198,636.00	23,328,654,397.56
31211	Төрийн сангийн харилцах	11,757,198,636.00	23,328,654,397.56
33	АВЛАГА	15,982,580,561.73	55,278,242.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,982,580,561.73	20,419,814.00
335	Бусад авлага	00.00	34,858,428.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	34,858,428.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,154,570.09	29,628,443.51
354	Хангамжийн материал	17,154,570.09	29,628,443.51
35410	Бичиг хэргийн материал	2,027,815.00	2,864,020.00
35420	Аж ахуйн материал	14,638,070.09	26,255,744.09
35440	Түлш, шатах тослох материал	488,685.00	508,679.42
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>246,922,734,358.20</b>	<b>325,959,059,449.54</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	246,922,734,358.20	325,959,059,449.54
392	Биет хөрөнгө	246,920,481,845.70	325,957,884,787.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	22,943,924,743.00	26,627,241,428.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,850,000.00	36,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,519,444.59	-28,661,111.31
39205	Машин тоног төхөөрөмж (комп)	172,535,046.83	228,179,626.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	-167,567,324.28	-171,543,150.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,355,791.52	134,110,791.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,336,482.64	-97,976,000.08
39209	Зам, гүүрийн байгууламж	13,141,682,050.00	15,046,603,704.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	210,773,138,465.86	284,182,660,498.86
39217	Ном	419,000.00	419,000.00
393	Биет бус хөрөнгө	2,252,512.50	1,174,662.50
39303	Бусад биет бус хөрөнгө	11,403,000.00	11,403,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-9,150,487.50	-10,228,337.50
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>274,679,668,126.02</b>	<b>349,373,309,132.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>11,757,772,892.00</b>	<b>5,933,394,697.00</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,757,772,892.00	5,933,394,697.00
413	Өглөг	11,757,772,892.00	5,933,394,697.00
4136	Бусад өглөг	11,757,772,892.00	5,933,394,697.00
41361	Байгууллагад төлөх өглөг	11,757,772,892.00	5,933,394,697.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>262,921,895,234.02</b>	<b>343,439,914,435.61</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	262,921,895,234.02	343,439,914,435.61
512	Хуримтлагдсан үр дүн	262,921,895,234.02	343,439,914,435.61
51210	Өмнөх үеийн үр дүн	262,921,895,234.02	262,921,895,234.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	80,518,019,201.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>274,679,668,126.02</b>	<b>349,373,309,132.61</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>189,601,645,460.65</b>	<b>84,929,116,682.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,248,521,755.62	4,140,503,770.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,248,521,755.62	4,140,503,770.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,248,521,755.62	1,242,101,770.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,219,507,580.62	1,230,951,770.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,050,000.00	11,150,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,964,175.00	00.00
120009	Бусад орлого	00.00	2,898,402,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	177,353,123,705.03	80,788,612,912.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	177,155,198,808.86	80,711,959,502.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,001,455,600.00	1,714,199,130.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	176,153,743,208.86	78,997,760,372.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	197,924,896.17	76,653,410.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	197,924,896.17	76,653,410.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,516,873,790.74</b>	<b>4,411,097,480.41</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,423,092,591.26	4,300,046,653.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,423,092,591.26	4,300,046,653.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,512,668.00	537,940,530.00
210101	Үндсэн цалин	379,545,700.00	436,621,803.00
210102	Нэмэгдэл	135,686,368.00	62,444,227.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	38,874,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,836,991.00	67,180,361.20
210201	Тэтгэврийн даатгал	62,836,991.00	67,180,361.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,031,733.00	54,376,032.00
210301	Гэрэл, цахилгаан	15,848,831.00	21,800,894.00
210302	Түлш, халаалт	18,003,080.00	24,076,837.00
210303	Цэвэр, бохир ус	7,179,822.00	8,498,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,596,189.52	36,299,063.39
210401	Бичиг хэрэг	14,840,105.00	13,840,515.00
210402	Тээвэр, шатахуун	14,436,843.00	6,241,005.58
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,622,082.52	13,961,542.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,697,159.00	2,256,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,105,400.00	11,697,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	450,000.00
210604	Урсгал засвар	3,105,400.00	11,247,400.00
2107	Томилолт, зочны зардал	45,658,093.00	15,533,715.00
210702	Дотоод албан томилолт	10,557,086.00	3,271,615.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	35,101,007.00	12,262,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,511,317.00	498,582,594.00

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,355,158.00	495,418,537.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	281,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,997,059.00	2,882,957.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,537,840,199.74	3,078,436,957.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,514,580,693.50	3,058,602,097.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,259,506.24	19,834,860.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,781,199.48	111,050,826.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	7,681,700.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	7,681,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	13,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	13,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	26,745,099.48	89,769,126.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,745,099.48	89,769,126.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>186,084,771,669.91</u></b>	<b><u>80,518,019,201.59</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>186,084,771,669.91</u></b>	<b><u>80,518,019,201.59</u></b>

### 4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>			262,921,895,234.02	262,921,895,234.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн				
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			262,921,895,234.02	262,921,895,234.02
<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>			262,921,895,234.02	262,921,895,234.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			262,921,895,234.02	262,921,895,234.02
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			80,518,019,201.59	80,518,019,201.59
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			<b>343,439,914,435.61</b>	<b>343,439,914,435.61</b>

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>206,676,987,625.09</u></b>	<b><u>101,309,192,243.73</u></b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,323,289,664.06	20,415,449,350.56
120	Нийтлэг татварын бус орлого	29,323,289,664.06	20,415,449,350.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,223,176,028.06	17,119,552,350.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,219,507,580.62	17,108,402,350.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,003,668,447.44	11,150,000.00
120009	Бусад орлого	11,100,113,636.00	3,295,897,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	177,353,697,961.03	80,893,742,893.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	177,155,198,808.86	80,711,959,502.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,001,455,600.00	1,714,199,130.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	176,153,743,208.86	78,997,760,372.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	198,499,152.17	181,783,391.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	197,924,896.17	76,653,410.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	574,256.00	00.00
131106	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	105,129,981.17
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>19,479,130,780.23</u></b>	<b><u>10,680,887,930.17</u></b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,479,130,780.23	10,680,887,930.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,402,769,019.02	10,549,417,289.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	560,512,668.00	537,940,530.00
210101	Үндсэн цалин	379,545,700.00	436,621,803.00
210102	Нэмэгдэл	135,686,368.00	62,444,227.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	38,874,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,836,991.00	67,180,361.20
210201	Тэтгэврийн даатгал	62,836,991.00	67,180,361.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,031,733.00	54,376,032.00
210301	Гэрэл, цахилгаан	15,848,831.00	21,800,894.00
210302	Түлш, халаалт	18,003,080.00	24,076,837.00
210303	Цэвэр, бохир ус	7,179,822.00	8,498,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,532,123.52	37,434,134.81
210401	Бичиг хэрэг	14,991,570.00	12,591,520.00
210402	Тээвэр, шатахуун	14,795,323.00	6,261,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,622,082.52	13,961,542.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,123,148.00	4,620,072.00

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,105,400.00	16,046,728.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,799,328.00
210604	Урсгал засвар	3,105,400.00	11,247,400.00
2107	Томилолт, зочны зардал	45,658,093.00	25,533,715.00
210702	Дотоод албан томилолт	10,557,086.00	13,271,615.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	35,101,007.00	12,262,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,511,317.00	514,315,069.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,355,158.00	511,151,012.00
210803	Даатгалын үйлчилгээ	89,100.00	281,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,997,059.00	2,882,957.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,514,580,693.50	9,296,590,719.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,514,580,693.50	9,296,590,719.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,076,361,761.21	131,470,640.99
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	7,681,700.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	7,681,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,036,100.00	13,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,000,000.00	13,600,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,536,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,009,325,661.21	110,188,940.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,009,325,661.21	110,188,940.99
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>187,197,856,844.86</u></b>	<b><u>90,628,304,313.56</u></b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	176,153,743,208.86	79,056,159,952.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	176,153,743,208.86	79,056,159,952.00
2200	Дотоод эх үүсвэрээр	176,153,743,208.86	79,056,159,952.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	176,153,743,208.86	79,056,159,952.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>- 176,153,743,208.86</u>	<u>- 79,056,159,952.00</u>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	11,044,113,636.00	11,572,144,361.56
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	713,085,000.00	11,757,198,636.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	11,757,198,636.00	23,329,342,997.56

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	80,715,952,472.00	80,621,626,220.01	94,326,251.99	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,718,192,100.00	1,623,865,848.01	94,326,251.99	94.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,696,910,400.00	1,602,584,148.01	94,326,251.99	94.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566,866,700.00	537,940,530.00	28,926,170.00	94.9
Үндсэн цалин	448,722,200.00	436,621,803.00	12,100,397.00	97.3
Нэмэгдэл	72,863,900.00	62,444,227.00	10,419,673.00	85.7
Унаа хоолны хөнгөлөлт	45,280,600.00	38,874,500.00	6,406,100.00	85.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,211,900.00	67,180,361.20	3,031,538.80	95.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,149,100.00	54,376,032.00	6,773,068.00	88.9
Гэрэл, цахилгаан	29,439,400.00	21,800,894.00	7,638,506.00	74.1
Түлш, халаалт	21,730,500.00	24,076,837.00	- 2,346,337.00	110.8
Цэвэр, бохир ус	9,979,200.00	8,498,301.00	1,480,899.00	85.2
Хангамж, бараа материалын зардал	42,504,700.00	42,456,274.81	48,425.19	99.9
Бичиг хэрэг	12,655,700.00	12,591,520.00	64,180.00	99.5
Тээвэр, шатахуун	7,392,000.00	6,261,000.00	1,131,000.00	84.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,079,900.00	13,961,542.81	3,118,357.19	81.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,377,100.00	9,642,212.00	- 4,265,112.00	179.3
Эд хогшил, урсгал засварын зардал	69,447,000.00	69,424,168.00	22,832.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	55,890,000.00	58,176,768.00	- 2,286,768.00	104.1
Урсгал засвар	13,557,000.00	11,247,400.00	2,309,600.00	83.0
Томилолт, зочны зардал	25,580,900.00	25,533,715.00	47,185.00	99.8
Дотоод албан томилолт	24,194,200.00	13,271,615.00	10,922,585.00	54.9
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,386,700.00	12,262,100.00	-10,875,400.00	884.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	564,483,700.00	514,315,069.00	50,168,631.00	91.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	557,426,000.00	511,151,012.00	46,274,988.00	91.7
Даатгалын үйлчилгээ	1,485,000.00	281,100.00	1,203,900.00	18.9
Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	-	396,000.00	-

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,998,700.00	2,882,957.00	115,743.00	96.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,178,000.00	-	2,178,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	296,666,400.00	291,357,998.00	5,308,402.00	98.2
Бараа үйлчилгээний бусад зардал	296,666,400.00	291,357,998.00	5,308,402.00	98.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,281,700.00	21,281,700.00	-	100.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,681,700.00	7,681,700.00	-	100.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	7,681,700.00	7,681,700.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	13,600,000.00	13,600,000.00	-	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,600,000.00	13,600,000.00	-	100.0
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>78,997,760,372.00</b>	<b>78,997,760,372.00</b>	-	<b>100.0</b>
Дотоод эх үүсвэрээр	78,997,760,372.00	78,997,760,372.00	-	100.0
Бусад хөрөнгө	78,997,760,372.00	78,997,760,372.00	-	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>80,715,952,472.00</b>	<b>80,622,314,820.00</b>	<b>93,637,652.00</b>	<b>99.9</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>80,715,952,472.00</b>	<b>80,622,314,820.00</b>	<b>93,637,652.00</b>	<b>99.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	80,715,952,472.00	80,622,314,820.00	93,637,652.00	99.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	688,600.00		
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>56</b>	<b>55</b>		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	53	52		
Үйлчлэх ажилтан	2	2		

## 5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

### Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>2018 он</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Санхүүгийн тайлангийн аудит</b>	<b>САГ-2019/304/СТА-ТШЗ</b>
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Үндэсний хөгжлийн газар</b>		<b>мянган төгрөгөөр</b>	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	<p>- Хадатын хүрээ ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдөр ҮХГ/079 дугаартай "Байгууллагын чиг үүргийн шинжилгээ, давхардал хийдлийг арилгах судалгааны ажлыг гүйцэтгүүлэх гэрээ"-г байгуулж 9,300.0 мянган төгрөгийн төлбөртэй гүйцэтгүүлсэн,</p> <p>- Жи Эс Эй Эс ХХК-тай 2018 оны 12 дугаар сарын 7-ны өдөр ҮХГ/080 дугаартай "Концессын гэрээгээр хэрэгжүүлэх төслүүдийн бүртгэл хөтлөх, тэдгээрийн явц болон хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж ажлын үр дүнг харгалзахгүйгээр 8,963.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,</p> <p>- Тайлант онд гадаад албан томилолтоор ажиллахдаа бизнес ангиллын нислэгээр зорчиж илүү төлсөн 6,544.5 мянга, томилолтын хугацааг хэтрүүлэн ажилласан хугацаанд тооцож олгосон 5,083.5 мянга, нийт 11,628.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.</p>	29,891.5	Албан шаардлага өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг

Үндэсний хөгжлийн газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Удам соел ХХК-тай 2018.12.26-ны өдөр байгуулсан "Судалгаа, шинжилгээний ажлын болон үйл ажиллагааны тайлангийн эмхэтгэл хэвлүүлэх" ажлын гэрээнд гүйцэтгэх хугацаа заагаагүй, мөн төлбөрийг 100 хувь буюу 9,405.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлсэн, алданги тооцоогүй, ажил гүйцэтгэж дуусаагүй тул авлага үүссэн,	9,405.0	Зөвлөмж өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг
3	Барьцааны дансанд 2017 оны концессын эргэн төлөлтийн үлдэгдэл 4,786.274.3 мянган төгрөгийг байршуулсан ба хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлээгүй,	-	Зөвлөмж өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг
4	Бараа үйлчилгээний бусад зардлаас олгосон үйлчилгээний төлбөрөөс дарс, пивоны үнэ 264.4 мянган төгрөг, гадаад арга хэмжээний хүлээн авалтын зардалд 17,173.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	17,437.8	Зөвлөмж өгсөн	ҮХГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Баярсайхан М.Бямбахишиг
	<b>Дүн</b>	<b>56,734.3</b>			



